ХЭВЛЭЛ
МЭДЭЭЛЛИЙН
ЗӨВЛӨЛ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ТАЙЛАН

2019-2020

2020 он

Өмнөтгөл

Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) нь хэвлэл мэдээллийн байгууллага-редакцын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, иргэн, байгууллага аж ахуйн нэгжээс редакцын нийтлэл, нэвтрүүлэгт гаргасан өргөдөл гомдлыг барагдуулах үндсэн чиг үүргээ амжилттай хэрэгжүүллээ.

2019 онд ХМЗ-д иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 106 өргөдөл гомдол ирүүлсэн нь таван жилийн өмнөхөөс 5 дахин нэмэгдсэн үзүүлэлт юм.

Хэвлэл мэдээллийн байгууллага-редакцуудад 6, сэтгүүл зүйн багш оюутнуудад 3, ХМЗ-ийн гишүүд, ажлын албанд 11 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Эрүүл сэтгүүл зүйн аян, хуурамч мэдээлэлтэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд 3 үйл явдал, хэвлэл мэдээллийн салбарынхан болон олон нийтэд зориулсан хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага 12, хэвлэлийн бага хурал 5, кейс судалгаа, мониторингийн ажлыг 3 удаа тус тус зохион байгуулж, нийт 1000 гаруй хүнд хүрч ажиллажээ



Өргөдөл, гомдол шийдвэрлэлт

Хэвлэл мэдээллийн зөвлөл нь Сонин, сэтгүүл, сайтын Ёс зүйн хороо, Радио телевизийн Ёс зүйн хороотойгоор үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд тус хороод нь иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдлыг ХМЗ НҮТББ-ын Үйл ажиллагааны журам, Гомдол хүлээн авах, барагдуулах журам, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд тулгуурлан хэлэлцэж дүгнэлтээ гаргадаг. 2019 онд Ёс зүйн хороод тус бүр дөрвөн удаагийн хуралдаанаар 74 гомдолд дүгнэлт гаргажээ.

ХМЗ нь 2019 оны нэгдүгээр сараас арванхоёрдугаар сар хүртэлх хугацаанд нийт 106 өргөдөл гомдлыг хүлээн авсан. Үүнээс:

- РТВ-ийн Ёс зүйн хороонд 22 (21%)
- ССС-ын Ёс зүйн хороонд 84 (79%)

гомдол тус тус хаяглагдсан байна.



ХМЗ-ӨӨС ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ:

22 редакцад хаягласан өргөдлийг ГХАБЖ-ын 2.3–ын дагуу хугацаа хэтэрсэн, материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй, Зөвлөлийн чиг үүрэгт хамаарахгүй, гомдол үндэслэлгүй зэрэг шалтгаанаас Ажлын албанаас урьдчилсан хяналт хийж шийдвэрлэсэн.
9 редакцид хаягласан өргөдлийг хариуцагч редакц Хорооны хуралдаан болохоос өмнө дотооддоо шийдвэрлэсэн тул гомдол гаргагч өргөдлөө буцаан татсан.
74 редакцид хаягласан өргөдлийг хоёр Хорооны 8 удаагийн хуралдаануудаар хэлэлцэж, ӨГБЖ-ын 6.3-ийн дагуу дараах дүгнэлтийг гаргасан. Ингэхдээ 16 хариуцагч хэвлэл мэдээллийн байгууллагаас залруулга гаргасныг Хорооны хурлын шийдвэрт харгалзан үзсэн.

1) ӨГБЖ-ын 6.3.1 –ийн дагуу 24 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчөөгүй гэдгийг олон нийтэд мэдээлэх;
2) ӨГБЖ-ын 6.3.2-ын дагуу 14 редакцыг зөрчлөө өөрсдөө залруулсан, уучлал гуйсныг мэдэгдэж, нэрийг дурьдахгүйгээр олон нийтэд мэдээлэх;
3) ӨГБЖ-ын 6.3.3-ийн дагуу 36 редакцыг Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим зөрчсөн тул нэрийг дурьдаж олон нийтэд мэдээлэх

Ёс зүйн хороодын дүгнэлтээс харахад хариуцагч хэвлэл мэдээллийн редакцууд Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын дараах заалтуудыг нийтлэг зөрчжээ. Үүнд:

1.1-т заасан “Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ”
1.2-т заасан “Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ”
1.6-д заасан “Баталгаагүй мэдээлэл, таамаглал, ам дамжсан яриаг таамаг хэмээн тодорхой дурьдана”
1.8-д заасан “Буруутгагдсан, шүүмжлэгдсэн этгээдэд тайлбар өгөх боломж олгоно” гэсэн заалтууд багтаж байна.

Удирдах зөвлөлийн бодлогын шийдвэрүүд

ХМЗ-ийн Удирдах зөвлөл нь сонин/сэтгүүл, радио/телевиз, цахим сайтууд, орон нутгийн хэвлэл мэдээлэл, олон нийт/санаачлагчдын бүлэг гэсэн 5 салбар бүлгийг төлөөлөх 15 хүний бүрэлдэхүүнтэй. ХМЗ НҮТББ-ын дүрмийн 10.2-т заасны дагуу ажлын албанаас санал оруулсан үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлах, гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөмж чиг үүрэг өгөхөөс гадна хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтыг бэхжүүлэхтэй холбоотой бодлогын дараах шийдвэрүүдийг гаргалаа.

2019 онд ХМЗ-ийн Удирдах зөвлөл 4 удаагийн хурал хийж, дараах бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэн баталжээ.



ХМЗ-ийн Үйл ажиллагааны журмыг шинэчлэн батлав	Гомдол хүлээн авах, барагдуулах журамд нэмэлт өөрчлөлт оруулав	Сонгуулийн үеэр ХМЗ-ийн ажиллах түр журмыг батлав	Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд санал өгөв

Түүнчлэн ХМЗ-ийн бодлогын баримт бичгүүдэд гарсан нэмэлт өөрчлөлтүүд, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, өргөдөл гомдлыг хэрхэн барагдуулсан талаар олон нийтэд хандсан хоёр удаагийн хэвлэлийн бага хурлыг зохион байгуулж, нээлттэй мэдээлэл хийлээ. Удирдах зөвлөлийн гишүүдийг 3 удаагийн сургалтад хамруулж, сонгуулийн үед хэвлэл мэдээллийн зөвлөл хэрхэн ажиллах тухай, дижитал эрин үеийн хэвлэл мэдээлэлд гарч буй өөрчлөлтүүдэд ХМЗ-ийн үүрэг роль, бие даасан хараат бус өөрийн зохицуулалтын байгууллагыг санхүүгийн хувьд тогтвортой хөгжүүлэх төлөвлөгөө зэргийг хэлэлцлээ.

ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны гуравдугаар хурлын шийдвэрээр тус зөвлөлийн санхүүгийн үйл ажиллагаанд хараат бус аудитийн үнэлгээ хийлгэх ажлыг Голден Пэйж Аудит ХХК-аар гүйцэтгүүлж дүгнэлтийг хүлээн авав.

Тус аудитын компани нь ХМЗ НҮТТБ-ын 2017, 2018 оны Санхүүгийн Байдлын Тайлан, Тайлант Жилийн Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан, Өмчийн Өөрчлөлтийн Тайлан, Мөнгөн Гүйлгээний Тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, бусад тайлбар тодруулгад аудит хийж “зөрчилгүй санал дүгнэлт” -ийг хүргүүлсэн байна.

Нийгмийн Даатгалын Ерөнхий Газраас 2019 оны дөрөвдүгээр улиралд Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөт шалгалтыг ХМЗ НҮТББ-ын үүсгэн байгуулагдсанаас хойших буюу 2015-2018 оны санхүүгийн тайланд оруулаа. Шалгалтаар “Тус байгууллага нь Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хугацаанд нь үнэн зөв гарган өгч, өр авлага үүсээгүй ажилласан байна” гэсэн дүгнэлтийг мөн ирүүлжээ.

Сэтгүүл зүйн
ЁС ЗҮЙН ФОРУМ-2019

2019 оны аравдугаар сарын 30-нд Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан Сэтгүүл зүйн ёс зүйн гуравдугаар форумыг “Хэвлэлийн эрх чөлөө - Дижитал хувьсал” сэдвийн хүрээнд Фридрих Эбертийн Сан, ХБНГУ-ын Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр зохион байгууллаа. Дэмжигч байгууллагаар GoGo агентлаг, NTV телевиз хамтран ажиллав. Энэ удаагийн ёс зүйн форум Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хэрэгцээ шаардлагыг тандаж буй үед болсоноороо онцлог байв.

Форумын үеэр дараах сэдвүүдийн хүрээнд үндсэн болон туслах илтгэлүүд, панел хэлэлцүүлгүүд болсон юм.

- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө – сэтгүүл зүйн хараат бус байдал /үндсэн илтгэл/
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага /илтгэл/
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний хуулийн шинэчлэл /панел хэлэлцүүлэг/
- Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт, олон улсын туршлага /дүгнэлт, зөвлөмж/
- Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын үр нөлөө, амжилтын түүх /илтгэл/
- Дижитал эрх ба ёс зүй /панел хэлэлцүүлэг/

ҮР ДҮН:

- Форумын үеэр Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэн найруулахдаа хэвлэлийн эрх чөлөө, хараат бус байдлыг улам баталгаажуулах, сэтгүүл зүйн ёс зүй, хариуцлагын тогтолцоог хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтаар бэхжүүлэхэд онцгой анхаарал хандуулахыг хууль тогтоогч, шийдвэр гаргагчдын анхааралд хүргэлээ.
- Түүнчлэн хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангахад сэтгүүлчид "хоточ банхар"-ын үүргийг биелүүлэх эрх зүйн орчин байна уу?, үнэнд нийцсэн мэдээлэл авах иргэний эрхийг хамгаалахад хэвлэл мэдээллийн үүрэг оролцоо ямар түвшинд байгаа талаар хэлэлцлээ. Өөрийн зохицуулалт бол чанартай сэтгүүл зүйг хангах хамгийн шилдэг арга тул Монголын хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын институтыг бэхжүүлэхэд уг форум чухал ач холбогдолтой байв.
- УИХ, ХЗДХЯ-ны бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын төлөөлөл, Хэвлэл мэдээллийн зөвлөл, Хэвлэлийн Хүрээлэн, МСНЭ, Глоб Интернэшнл төв зэрэг хэвлэл мэдээллийн салбарын мэргэжлийн байгууллага, эвсэл холбоод, нийслэл болон орон нутгийн сэтгүүлчдийн төлөөлөл, Сэтгүүл зүйн их дээд сургуулиудын судлаач багш нар оролцож, харилцан мэдээлэл солилцсон нь салбарынхан дотроо асуудлаа ярилцаж, шийдэл эрэлхийлсэн форум болов.
- Форумаар хэлэлцсэн санал санаачилга, оролцогчдын байр суурийг ХМЗ анхааралдаа авч, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд өгөх саналыг Удирдах зөвлөлөөрөө хэлэлцэн батлав.
- Форумын хүрээнд хэлэлцсэн өөр нэг сэдэв нь дижитал эрхийн үеийн сэтгүүл зүйн ёс зүйн асуудал байлаа. Сүүлийн хоёр жилд ХМЗ-өөс дижитал эрин үеийн мэргэжлийн сэтгүүл зүйн талаар идэвхтэй санал санаачилга дэвшүүлсний хувьд "Цахим орчинд хэвлэл мэдээллийн редакцийн баримтлах бодлого" баримт бичгийг боловсруулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудад удирдамж хүргүүлэв.

Хэвлэл мэдээллийн бодлого цуврал дугуй ширээний ярилцлага

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Фридрих-Эбертийн Сантай хамтран "Хэвлэл мэдээллийн бодлого" цуврал дугуй ширээний ярилцлагыг 2018 онд эхлүүлсэнээс хойш дөрвөн удаагийн хэлэлцүүлэг хийлээ.

Энэ хүрээнд бид гүтгэлэг, доромжлолыг Зөрчлийн тухай хуулиар шийдэх нь хэвлэл мэдээллийн редакцад эдийн засгийн аргаар цензур тогтоож байна уу, цахим орчинд жирийн уншигчаас гадна сэтгүүлчид үзэн ядалтын үг хэллэгийг түгээхэд оролцдог уу, сонгуулийн үеэр хуурамч мэдээлэл олширдогтой бид хэрхэн тэмцэж чадах вэ, мөн Сонгуулийн тухай хууль хэвлэл мэдээллийнхэнд халтай юу зэрэг сэдвийг хөндөж, шийдэл хайсан хэлэлцүүлгүүдийг цувралаар зохион байгууллаа.

> 2019 онд бид дараах хоёр асуудалд хэвлэл мэдээллийн салбарынхны анхаарлыг хандуулсан юм.

- Тавдугаар сарын 1-ний өдөр 2020 оны сонгуулийг сэтгүүлчид ёс зүй, хариуцлагын өндөр түвшинд мэдээлж сурвалжлахад ХМЗ-ийн үүрэг ролийн талаар, хуурамч мэдээлэлтэй хэрхэн тэмцэж, үүнийг бууруулахад хэвлэл мэдээллийнхний оролцооны талаар хэлэлцлээ. Энэ удаагийн хэлэлцүүлгийг ЮНЕСКО-гоос Хэвлэлийн эрх чөлөөний өдрийг угтан зарласан "Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүл зүй ба сонгууль" уриан дор хийсэн бөгөөд ХБНГУ, Пакистан болон Монгол Улсын хэвлэл мэдээллийн салбарын төлөөлөгчид оролцож туршлагаа хуваалцсан нь онцлог байв.
- Есдүгээр сарын 23-нд болсон "Сонгуулийн тухай хууль ба хэвлэл мэдээлэл" дугуй ширээний ярилцлагыг 2019 оны сүүлээр УИХ-аар хэлэлцэхээр төлөвлөсөн Сонгуулийн тухай хуулийн төсөлд хэвлэл мэдээллийнхний саналыг хүргэх зорилгоор зохион байгуулсан болно. Сонгуулийн Ерөнхий Хороо, Харилцаа Холбооны Зохицуулах Хороо, Хэвлэл мэдээллийн мэргэжлийн байгууллагууд, эвсэл холбоод, редакцуудын төлөөлөл, ХМЗ-ийн гишүүд оролцож, тус хуулинд хэвлэл мэдээлэлтэй холбоотой хэсгүүдэд саналаа өглөө.

ҮР ДҮН:

- "Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүл зүй ба сонгууль" хэлэлцүүлгийн дараа хуурамч мэдээлэлтэй тэмцэх "Fact-Check Mongolia" хөтөлбөрийг ХМЗ дэмжин хэрэгжүүлж эхэлсэнийг олон нийтэд зарлав.
- Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Сонгуулийн үеэр хэрхэн ажиллах тухай бодлогын баримт бичгүүддээ нэмэлт оруулж, олон нийтэд зарлалаа. Тодруулбал, Гомдол хүлээн авах, барагдуулах журамд Сонгуулийн үеэр ажиллах журмыг нэмэлтээр тусгаж, мөн Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчимд нэмэлт 10 дахь заалтыг оруулаа. Тус заалтад "Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ" хэмээн заасан байдаг.
- "Сонгуулийн тухай хууль ба хэвлэл мэдээлэл" сэдэвт хэлэлцүүлгээс үүдэн хэвлэл мэдээллийн салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудаас нарийвчилсан санал авах, тэдгээрийг СЕХ болон Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт танилцуулах тухай албан бичгийг талуудад хүргэв.

Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл
FRIEDRICH EBERT STIFTUNG
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ
Дүгүй ширээний яриллага #4
Улаанбаатар хот
2019-09-23

йгуулагын 546 сурвалжлагч
43 улс, олон
TELEVISION
NEWSPAPERS

Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл
FRIEDRICH EBERT STIFTUNG
СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ
Дүгүй ширээний яриллага
Улаанбаатар хот

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага нийтлэл, нэвтрүүлэгтээ хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон, илт худал мэдээлэл тарааж, гүтгэсэн тохиолдолд энэ нь ёс зүйн хэм хэмжээнээс хальж хуулийн хариуцлага хүлээхэд хүргэдэг.
2002 оны Эрүүгийн хуульд байсан гүтгэх, доромжлох ерөнхий гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хуульд оруулаагүй нь маш чухал шинэчлэл болсон. Гэвч сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах гэмт хэргийг 2015 оны Эрүүгийн хуульд хэвээр үлдээж торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих гэсэн ялаар шийтгэхээр заасан. Харин гүтгэлэг, доромжлолыг Зөрчлийн тухай хуулиар хориглож хувь хүн болон хуулийн этгээдэд торгох шийтгэл ногдуулж байгаа нь Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай зөрчилдсөн, үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг зөрчиж, хэрэгжилтэд нь сөргөөр нөлөөлж байгаа талаар ХМЗ байр сууриа идэвхтэй илэрхийлж, салбарын хэлэлцүүлэг, сургалтуудыг цувралаар хийж ирсэн.
Энэ хүрээнд дараах хэд хэдэн чиглэлээр ажиллав.

- “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь” сэдэвт сургалтыг нийслэлийн 9 дүүргийн шүүгч нар болон Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээсэн сэтгүүлчдэд зориулан зохион байгууллаа.
- Эрүүгийн хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор ХМЗ-ийн Удирдах зөвлөлөөс эрдэмтэн судлаачдаас туршлага судлах, санал солилцох ажлуудыг идэвхтэй хийж, гүтгэх, доромжлохыг Эрүүгийн хуулиар шийдэж ирсэн практикт хөндлөнгийн үнэлгээ хийлгэв. ХМЗ-ийн захиалгаар хуульч судлаач О.Мөнхсайхан “Монгол Улс дахь гүтгэх, доромжлох гэмт хэргийн шүүхийн хэрэглээ 2011-2017 онд” судалгааны ажлыг гүйцэтгэж, ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүдэд танилцууллаа.
- Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшинг тогтоох судалгааны ажлыг Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Европын Холбооны дэмжлэгтэйгээр GSP+ буюу Хөнгөлөлтийн ерөнхий системээр дамжуулж хүний эрх, хөдөлмөрийн эрхийг хөхүүлэн дэмжих нь төслийн дэмжлэгтэйгээр Монголын Хуульчдын Холбоо болон Глоб Интернэшнл Төвтэй хамтран хийсэн. Судалгаанд оролцсон сэтгүүлчдийн олонх нь мэдээлэл олж авахад саадтай байдаг, дарамт сүрдүүлэгт өртдөг, мөн ажлын багаж хэрэгсэлд халдаж байсан тохиолдлууд нийтлэг байдаг гэжээ.
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн хэлэлцүүлгийн явцад ажлын хэсгийн гишүүдэд тодорхой санал санаачилгыг хүргүүлж ажилласны үр дүнд Радио, телевизийн үйлчилгээ эрхлэгчид ёс зүйн өөрийн зохицуулалт хийх эрхийг баталгаажуулав.

СЭТГҮҮЛ ЗҮЙН ЧАНАРЫН
цуврал сургалт, уулзалтууд

4 сар, 9 сар

Дөрөв болон есдүгээр сард ХМЗ-ийн Ёс зүйн хорооны гишүүдэд зориулсан бүх гишүүдийн сургалтыг хоёр удаа зохион байгууллаа. Сургалтаар ХМЗ-ийн үйл ажиллагаа болон ГХАБЖ-ын хэрэгжилт, сайжруулалт, ёс зүйн хорооны гишүүдийн үүрэг, хариуцлагын тухай ярилцахаас гадна ёс зүйн хороонд ирүүлсэн өргөдлийг хэрхэн оновчтой, үр дүнтэй хэлэлцэн шийдвэрлэх талаар туршлага хуримтлуулсан. Сургагчаар Германы хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга Манфред Протце ажиллав. ХМЗ-ийн Удирдах зөвлөл, Ёс зүйн хороод болон Ажлын албаны гишүүд дээрх сургалтуудад оролцсон болно.

1 сар

Нэгдүгээр сарын 16-нд “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь” сэдэвт сэтгүүлчдэд зориулсан сургалт, хэлэлцүүлгийг Дойче Веллэ Академийн дэмжлэгтэй зохион байгуулав. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн доктор, профессор О.Мөнхсайхан, МСНЭ-ийн Ерөнхийлөгч Х.Мандахбаяр нар уг сургалтад оролцож гүтгэлэг, доромжлолыг хэрхэн зохицуулж ирсэн туршлага, Монголын хэвлэл мэдээллийн эрх зүйн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл хийлээ.

4 сар

Дөрөвдүгээр сарын 4-нд зохион байгуулагдсан “Нийгмийн сүлжээ ба зохистой хэрэглээ-2019” форумын үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа “Нийгмийн сүлжээний боломж ба эерэг хандлагыг бий болгох нь” панел хэлэлцүүлгийн хэсэгт нийгмийн сүлжээ болон мэргэжлийн сэтгүүл зүйн ялгаа, эрсдэл ба боломжийн талаар санал бодлоо хуваалцав.



4 сар

Дөрөвдүгээр сарын 25-наас тавдугаар сарын 3-ны хооронд ХМЗ-ийн Удирдах зөвлөл, Ёс зүйн хороодын гишүүд, ажлын албаныханд зориулсан цуврал уулзалт, сургалтуудыг зохион байгууллаа. Сонгуулийн үед хэвлэл мэдээллийн зөвлөлийн үүрэг роль, цахим орчинд ялангуяа сошиал медиа дахь сэтгүүлчийн ёс зүйн асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн юм.

5 сар

Тавдугаар сарын 2-ны өдөр Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан олон нийтэд мэдээлэл өглөө. Энэ үеэр сонгуулийн үеэр хэрхэн ажиллах шинэ зохицуулалтууд болон хэвлэл мэдээллийн байгууллагын нийгмийн сүлжээн дэх албан ёсны хуудсанд ирүүлсэн гомдлыг хүлээж авч эхэлсэнээ мэдэгдэв. Хэвлэлийн бага хуралд УЗ-ийн дэд дарга У.Тамир, УЗ-ийн гишүүн С.Шаравдорж, ХМЗ-ийн Хэвлэлийн төлөөлөгч Д.Нарантуяа, Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа нар оролцлоо.

5 сар

Тавдугаар сарын 1-нд Фредрих-Эбертийн Сан, Глоб Интернэшнл Төв Нээлттэй Нийгэм Форумтай хамтран "Хуурамч мэдээллийн үе дэх сэтгүүл зүй ба сонгууль" хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэ үеэр "Сонгууль ба хуурамч мэдээлэл", "Хэвлэл мэдээлэл ба хуурамч мэдээлэл", "Сонгогчдын боловсрол ба хуурамч мэдээлэл" гэсэн дэд сэдвүүдийн дор сонгуулийн үеийн сэтгүүл зүй, цахим сайт болон нийгмийн сүлжээний зохицуулалт, сонгуулийн үеийн нийгмийн сүлжээний мониторинг хуурамч мэдээллийг таних нь зэрэг сэдвээр санал солилцож, хэлэлцүүлэг өрнүүлсэн.

5 сар

Тавдугаар сарын 4-нд ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1 (Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ) заалтын хэрэгжилтийг дэмжих, хуурамч мэдээлэлтэй тэмцэх зорилготой Fact Check Mongolia хөтөлбөрийг нээж үг хэлэв. Уг хөтөлбөрийг ХМЗ-ийн санаачилгаар Дойче Веллэ Академийн дэмжлэгтэйгээр Эрэн сурвалжлах сурвалчлагчдын төлөө төв хэрэгжүүлж эхэллээ.

8 сар

Наймдугаар сарын 22-ноос 24-ний өдрүүдэд “Сэтгүүлчийн ёс зүй ба хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт” сэдэвт их дээд сургуулиудын сэтгүүл зүйн багш нарт зориулсан гурван өдрийн сургалт болов. Сургалтыг ХБНГУ-ын Бохумийн их сургууль, Хэвлэл мэдээлэл судлалын төвийн Медиа системийн олон улсын харьцуулалтын доктор, профессор Барбара Томасс удирдан явуулсан энэхүү сургалтын үр дүнд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын талаар 5 өдрийн сургалтын хөтөлбөрийг сэтгүүл зүйн багш нарт танилцуулж, хүлээлгэн өглөө.

9 сар

Есдүгээр сарын 7, 8-ны өдрүүдэд “Цахим орчинд ёс зүйн зарчмыг хэрэгжүүлэх нь” сэдэвт хоёр өдрийн сургалтыг ХМЗ-ийн нийт гишүүдэд зориулан хийлээ. Сургагч Манфред Протце Европын улс орнуудад дижитал орчин дахь сэтгүүл зүйн бүтээлтэй холбоотой гомдлыг хэрхэн шийдэж буй талаарх туршлагаасаа хуваалцав.

9 сар

Есдүгээр сарын 5-нд “Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүд оролцож, ХМЗ-ийн санхүүжилтын өнөөгийн байдал, цаашдын төлөвлөгөө, боломж, эрсдэлийн талаар хэлэлцэв.

9 сар

Есдүгээр сарын 13-ны өдөр Монголын бизнесийн зөвлөлөөс Монгол дахь Канадын ЭСЯ-тай хамтран хэрэгжүүлж буй “Сэтгүүлчдийн чадавхийг бэхжүүлэх” сургалтад ХМЗ-өөс сэтгүүл зүйн ёс зүй, хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын сэдвээр илтгэл танилцуулав.

10 сар

Аравдугаар 11-нд Монголын Сайтын Холбоотой хамтран “Цахим сэтгүүл зүй ба мэргэжлийн ёс зүй” сэдэвт сургалтыг хамтран зохион байгууллаа. Уг сургалтад ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн гишүүн Б.Боргилмаа, ССС-ын Ёс зүйн хорооны гишүүн Э.Энэрэл, Б.Цоожчулуунцэцэг, РТВ-ийн Ёс зүйн хорооны гишүүн Ц.Чимиддондог нар оролцож мэдээлэл хийж, туршлагаасаа хуваалцав.

10 сар

Аравдугаар сарын 29-ний өдөр ХМЗ-ийн гишүүд болон хуульч, судлаачдад зориулсан "Дижитал эрхийн үзэл баримтлал" сэдэвт сургалтыг Дойче Веллэ Академитай хамтран зохион байгуулав. Энэ үеэр ДВА-ийн Сошиал медиа, дижитал эрхийн сургалт хариуцсан эксперт Юлиус Эндерт, Глоб Интернэшнл Төвийн тэргүүн Х.Наранжаргал, ХХЗХ-ны тусгай зөвшөөрлийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Х.Нинжболор нар мэдээлэл хийлээ.

11 сар

Арваннэгдүгээр сарын 22-ны өдөр АТГ-тай хамтран "Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ёс зүй ба сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт нэг өдрийн сургалтыг зохион байгууллаа. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан "Хууль сахиулах байгууллагын ажилтан, албан хаагчдад эрэн сурвалжлах сэтгүүл зүй, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах талаар сургалт хийх, тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгууллаа.

12 сар

Арванхоёрдугаар сарын 19, 20-ны өдрүүдэд ХМЗ-өөс Глоб Интернешнл Төв, Монголын Хуульчдын Холбоотой хамтран Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр "Хэвлэл мэдээллийн эрх зүйгээр мэргэшсэн сургагч багш бэлтгэх" сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн баталгаа", "Цахим эрх, эрх чөлөө", "Сэтгүүл зүйн үндсэн ойлголт", "Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, өөрийн зохицуулалт", "Сэтгүүлчийн аюулгүй байдал" зэрэг сэдвүүдийг хамарч, сургагч багш нар харилцан туршлага солилцов.

11 сар

Арваннэгдүгээр сарын 1-нд Глоб Интернэшнл Төвөөс "Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр"-т зориулан "Үнэн амьд байгаа" хэвлэлийн бага хурлыг зохион байгуулсан. Тус хэвлэлийн хуралд ХМЗ-ийг төлөөлж сэтгүүл зүйн багш, судлаач А.Амартүвшин оролцож "Сэтгүүлчийн аюулгүй байдлын түвшин тодорхойлох судалгаа"-ны үр дүнг танилцууллаа.

10-12 сар

Fact-Check Mongolia хөтөлбөрийн хүрээнд аравдугаар сарын 22-ноос 25, арванхоёрдугаар сарын 2-ноос 6-ны хооронд хоёр удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтыг ЭССТ-өөс Дойче Веллэ Академийн дэмжлэгтэй хэрэгжүүлсэн бөгөөд нийт 16 редакцын төлөөлөл хамрагдсан.

12 сар

Арванхоёрдугаар сарын 30-нд хуурамч мэдээлэлтэй тэмцэх www.factcheck.mn сайтын нээлтэд ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа оролцож, хөтөлбөрийн үр дүнг онцолж, цаашид хэрэгжилтэд дэмжин ажиллахаа илэрхийллээ.

2019 он

2019 онд хэвлэл мэдээллийн редакцуудад зочлох, сэтгүүлчдэд болон олон нийтэд ХМЗ-ийн үйл ажиллагааг танилцуулах ажлыг үргэлжлүүлэн хийж СУИС-ийн Радио Телевиз Медиа урлагийн сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Монгол телевиз, Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс, МҮОНР, Идэр дээд сургууль, Хэвлэлийн хүрээлэнгийн Сэтгүүл зүйн дээд курсынхэнд мэдээлэл өглөө.

FACT CHECK MONGOLIA

6 сар

Зургаадугаар сарын 7-нд ОНХМХ-оос Завхан аймагт зохион байгуулсан баруун хойд бүсийн сэтгүүлчдэд зориулсан "Орон нутгийн хэвлэл мэдээлэл ба нээлттэй засаг" сургалт семинарт ХМЗ-ийн төлөөллүүд оролцож, мэдээлэл хийлээ. Уг семинарт ХМЗ-ийн УЗ-ийн дэд дарга У.Тамир, УЗ-ийн гишүүн С.Шаравдорж, ССС-ын ёс зүйн хорооны гишүүн Д.Нарантуяа нар оролцов.

Олон нийтэд **зориулсан** ажлууд

Гомдол хүлээж авах, барагдуулах журмын хэрэгжилтийн дагуу ХМЗ-ийн хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл гомдлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар 8 удаагийн хэвлэлийн мэдээ бэлтгэж, олон нийтэд нээлттэйгээр байршууллаа/ http://www.mediacouncil.mn/as/shiidver /. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр түгээв.





ХМЗ-ийн Удирдах зөвлөлийн санаачилгаар олон нийтэд хандсан хоёр удаагийн Хэвлэлийн бага хурлыг нээлттэй зарлан хийлээ. Сэтгүүлчийн ёс зүйтэй холбоотойгоор хүлээн авсан гомдол, тэдгээрийн шийдвэр болон сэтгүүлч, редакцуудын гаргадаг түгээмэл алдааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл хийсэн. Харин 2019 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хийсэн хэвлэлийн хурлын үеэр ХМЗ-өөс сонгуулийн үеэр хэрхэн ажиллах талаар Гомдол хүлээн авах, барагдуулах журамдаа нэмэлт оруулсан тухай, Ёс зүйн зарчимд шинэ заалт тусгасан тухай мэдээлэл өгсөн. ХМЗ-өөс ёсзүйн зөрчилтэй хэмээн үзсэн иргэдийн гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар мөн мэдээлэл өглөө.

Хэвлэл мэдээллийн ёс зүйн өдрийг 9 дүгээр сарын сүүлийн долоо хоногт уламжлал болгон тэмдэглэн өнгөрүүлэв. Энэ удаад “ХМЗ-ийн гишүүд ярьж байна” сэдвийн хүрээнд УЗ-ийн дэд дарга У.Тамир, УЗ-ийн гишүүн С.Шаравдорж, Д.Норжмаа, РТВ-ийн Ёс зүйн хороон дарга Ш.Сүхбаатар, ССС- ын Ёс зүйн хорооны гишүүн Д.Нарантуяа, Б.Туяа, О.Амарзаяа, Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа нар ХМЗ хэрхэн ажилладаг вэ, сонгуулийн үеэр хэрхэн ажиллах вэ, ГХАБЖ болон зарчимдаа ямар нэмэлтүүд тусгав? Сонгуулийн үед хэвлэл мэдээлэл үүргээ биелүүлж, сонгогчдын мэдэх эрхийг хангаж ажиллах, хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд бид ямар ажлууд эхлүүлээд байгаа талаар ярилцлага мэдээлэл өгөв.

Хэвлэл мэдээллийн зөвлөлийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байх бодлогын хүрээнд улирал тутам цахим сэтгүүл гаргаж, олон нийтэд түгээж байна. Өнгөрсөн онд нийт 4 дугаар гаргаж танилцуулав.

ХМЗ-ийн 2018-2019 оны үйл ажиллагаа болон санхүүжилтын талаарх мэдээлэл бүхий Жилийн тайланг монгол, англи хэлээр хэвлүүлж, хэвлэл мэдээллийн байгууллага, дэмжигч байгууллагуудад хүргүүлэв. Мөн тайланг www.mediacouncil.mn сайтад олон нийтэд нээлттэйгээр байршуулав.

ХМЗ-ийн өргөдөл гомдлын статистик мэдээлэл болон Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмыг агуулсан постерийг хэвлүүлж мөн иргэд болон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нээлттэй түгээж байна.

ХМЗ-өөс санаачлан "Миний мөрөөдлийн сэтгүүл зүй" шилдэг эссэ бичлэгийн уралдааныг сэтгүүл зүйн их дээд сургуулийн оюутнуудын дунд зохион байгууллаа. Уралдаанд 60 гаруй оюутан бүтээлээ ирүүлснээс ХУИС-ийн 2-р дамжааны оюутан М.Мөнхжин тэргүүн байрыг эзэлж, Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2019-ийг илтгэлээрээ нээлээ.

2015-2019 оны өргөдөл гомдол болон бусад албан бичгийн архивын хадгалалт, аюулгүй байдлыг хамгаалахын тулд "Цахим сан" ажлыг ДВА төслийн дэмжлэгтэй хэрэгжүүлж эхэлсэн. 2019 оны 10 дугаар сараас эхлэн гомдол бүрийн холбогдох материалуудыг скандардаж бүртгэлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Энэ хугацаанд нийт 9425 хуудас материалыг сканардаж, чанарыг сайжруулан, төрлөөр ангилан цахим архив үүсгээд байна.

Мэдээлэл сурталчилгааны **ХЭВЛЭМЭЛ** бүтээгдэхүүнүүд

ХМЗ-өөс 2019-2020 онд дараах гарын авлага, танилцуулга, тараах материал, сурталчилгааны бүтээгдэхүүнийг бэлтгэж, сэтгүүл зүйн салбарынхан болон бусад зорилтот бүлэгт түгээв.



150 ш

“ЁС ЗҮЙН ФОРУМ 2019” ЛОГОТОЙ ДААВУУН УУТ

500 ш

“ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ БА АРДЧИЛАЛ” БРОШУР

300 ш

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ГОМДЛЫН СТАТИСТИК, ЁС ЗҮЙН ЗАРЧИМ ПОСТЕР

Туршлага солилцох аялал

ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа 2019 оны тавдугаар сарын 27-28-нд Монгол дахь ХБНГУ-ын ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр Бонн хотноо болсон "Дэлхийн хэвлэл мэдээллийн форум"-д оролцлоо. Тус форумд 140 гаруй орны 2500 орчим сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэн оролцсон. Арванхоёр дахь удаагаа зохион байгуулагдаж буй энэхүү форум нь "Хүчнүүдийн шилжилт" (Shifting Powers) сэдвийн дор болж, хэвлэл мэдээллийн хүчийг хэн атгаж байна, тэр нь сэтгүүл зүйн хараат бус байдал, чанарт хэрхэн нөлөөлж буйг хэлэлцсэн юм.

ХМЗ-ийн ССС-ын Ёс зүйн хорооны гишүүн, хэвлэлийн төлөөлөгч Д.Нарантуяа 2019 оны 7 дугаар сарын 17-18-нд Киргизстан Улсын Бишкек хотноо болсон Төв Азийн хэвлэл мэдээллийн форумд оролцож, Монгол дахь хэвлэл мэдээллийн эрх чөлөөний байдал сэдвээр илтгэл танилцууллаа. Тус форумд төв Азийн орнуудаас 100 гаруй төлөөлөгч оролцов.

ХМЗ-ийн РТВ-ийн ёс зүйн хорооны дарга Ш.Сүхбаатар, ССС-ын ёс зүйн хорооны гишүүн Д.Нарантуяа нар байгууллагаа төлөөлөн Непалийн Хэвлэлийн зөвлөлийн тэргүүн, Дэлхийн Хэвлэлийн зөвлөлүүдийн ассоциацийн /World Association of Press Councils/ Ерөнхий нарийн бичгийн дарга Кишор Шрестатай 10 дугаар сарын 4-ний өдөр уулзлаа. Уулзалтын үеэр ХМЗ-ийн үйл ажиллагаа, ёс зүйн хорооны шийдвэр, үр дүнгийн талаар танилцуулж, санал солилцсон юм. Ноён Кишор Шреста Монголын ХМЗ-ийг Дэлхийн хэвлэлийн зөвлөлүүдийн ассоциацийн гишүүнээр элсэхийг урьж, бүс нутагт болж буй арга хэмжээнүүдэд оролцож, чанартай сэтгүүл зүйг хөгжүүлэх үйлсэд нэгдэхийг хүслээ.

ХМЗ-ийн төслийн зохицуулагч Н.Ганчимэг 2019 оны 12 дугаар сарын 9-нөөс 13-ны өдрүүдэд ХБНГУ-ын Бонн хотод болсон ДВА-ийн хамтрагч байгууллагуудын захиргааны ажилтнуудад зориулсан "Төслийн захиргаа, санхүү" сэдэвт сургалтад хамрагдав.



17-18
MEDIA FREEDOM
AND PLURALISM
СВОБОДА И

news
agency
news
news
news

GLOBAL
MEDIA
FORUM

Дотоодын ХАМТЫН АЖИЛЛАГАА, түншлэл

■ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дарга Н.Лүндэндорж ХМЗ-ийн Гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа, Германы Хэвлэлийн зөвлөлийн орлогч дарга ноён. Манфред Протце нарыг 2019 оны нэгдүгээр сарын 17-нд хүлээн авч уулзлаа. Тус уулзалтаар хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйгээ сахин мөрдөх, үүнийг хэрэгжүүлэхийн төлөө ажилладаг өөрийн зохицуулалтын байгууллагатай байхын чухлыг онцолж, шүүгчдэд хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, өөрийн зохицуулалтын байгууллагын шийдвэрийн талаар сургалт, мэдээлэл өгөхөд дэмжиж ажиллах нь нээлттэй хэмээн тэрээр мэдэгдэв. 2019 оноос шүүгчдийн тогтмол сургалтын хөтөлбөрт Хүний эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын тухай багтаж, 400 гаруй шүүгчдэд ХМЗ-ийн тайлан, танилцуулгыг түгээв.

■ Хайнс Зайделийн Сангийн тэргүүн Ц.Сарантуяатай ХМЗ-ийн удирдлагууд уулзлаа. Тус сангийн дэмжлэгтэйгээр хэвлэл мэдээлэлтэй холбоотой хуулийн шинэчлэлд шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах боломжийг хэлэлцэв.

■ Сэтгүүл зүйн их дээд сургуулиудын Ёс зүйн хичээл заадаг багш нарт Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тухай 5 өдрийн сургалтын хөтөлбөрийг санал болгож, үүнийг оюутнуудад хэрхэн заах талаар 3 өдрийн сургалтад хамруулав. Ингэснээр сэтгүүл зүйн ёс зүйн хичээлийн хөтөлбөрт хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын сэдвийг шинэчлэн тусгуулсан юм. Уг хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх цогц сургалтад МУБИС, Хүмүүнлэгийн Ухааны ИС, Отгонтэнгэр ИС, СУИС-ийн дэргэдэх Радио

ТВ-ийн сургууль, Хэвлэлийн Хүрээлэн, Эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн сургагч багш нарыг хамруулсан. МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд мөн сургалтын хөтөлбөрийг хүлээлгэн өгөв.

■ Хуурамч мэдээлэлтэй тэмцэх хүрээнд Fact Check Mongolia хөтөлбөрийг Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв /MCIR/-тэй хамтран ДВА-ын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэллээ. Мэргэжлийн сэтгүүлчдийн факт-чек хийх ур чадварыг хөгжүүлэх зорилготой уг хөтөлбөрт 20 орчим мэргэжлийн хэвлэл мэдээллийн редакцыг эгнээндээ нэгтгээд байна.

■ МУ-ын Засгийн газраас хэрэгжүүлж буй Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн эхний үе шатыг хэрэгжүүлэхэд ХМЗ хэрэгжүүлсэн ажлынхаа талаар тайланг хүргүүллээ. ХМЗ нь тус хөтөлбөрийн 8 дугаар хэсэг буюу Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр 2 удаагийн сургалт хийж, сэтгүүлчийн аюулгүй байдлын мониторинг хийлээ.

● “Хүүхэд-Хэрэглэгч” үндэсний өдрийн үеэр хүүхдийн эрүүл аюулгүй байдал, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, тэгш эрхийг хангах, ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор БСШУСЯ, ХНХЯ, ХХМТГ, ХХЗХ, МТХ, ХМЗ гэсэн зургаан байгууллага харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Санамж бичгийн хүрээнд телевиз, өргөн нэвтрүүлгийн орон зай, ёс зүй болон цахим орчинд хүүхдийн эрүүл мэнд, хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлэхүйц агуулга бүхий контент, кино зар сурталчилгаа хүүхдэд нөлөөлөхөөс сэргийлж хамтран ажиллах юм.

■ Монголын Хуульчдын Холбоо, Глоб Интернешнл Төвтэй хамтран Хэвлэл мэдээллийн эрх зүйгээр мэргэшсэн сургагч багш нар бэлтгэх урт хугацааны хөтөлбөрийг санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлж байна.

■ Хэвлэл мэдээллийн салбарын эрх зүйн орчинг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах, сэтгүүлчийн ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх чиглэлээр асуудал хөндөж, гарц шийдэл хайдаг “Сэтгүүл зүйн ёс зүйн форум”-ыг Фридрих-Эбертийн Сан, Дойче Веллэ Академи, GoGo агентлаг, NTV телевизтэй хамтран гурав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

■ МСНЭ-ийн санаачилгаар Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын сайтын холбоо, ХХЗХ хамтран “Эрүүл сэтгүүл зүйн төлөө” аяныг эхлүүлсэн. Уг аяны хүрээнд 2019 оны 6 дугаар сарын 14-ний өдөр мэдээллийн сайтуудын дунд оюуны өмчийг дээдлэх, хаягжилтыг бүрэн болгох уриалга гаргалаа.

■ Хэвлэл мэдээллийн редакцуудыг цахим орчин, сошиал медиатай хэрхэн харьцах талаарх бодлогын баримт бичигтэй болохыг ХМЗ уриалсаар ирсэн. Энэ онд ХМЗ-өөс санаачлан “Цахим орчинд редакцийн баримтлах бодлого” гарын авлагыг боловсруулаа.

Санхүүжилт

2019 онд ХМЗ нийт 164,947,330 төгрөгийн мөнгөн орлоготой, нийт 150,010,364 төгрөгийн мөнгөн зардалтай ажиллажээ. Орлогын бүрдэлт: дотоод эх үүсвэр 20%, төслийн эх үүсвэр 80%.
Орлогын эх үүсвэр нь хандив, хэвлэл мэдээллийн байгууллагуудын дэмжлэг, төслийн үйл ажиллагааны орлогоос бүрдэж байна.



ОРЛОГЫН БҮРДЭЛТ



ХМЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫГ ТӨРЛӨӨР ХАРУУЛБАЛ:



Цалин, даатгал, татварын зардал

Ашиглалтын болон үйл ажиллагааны тогтмол зардал

Төслийн үйл ажиллагааны зардал

2019 ОНД ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ ДЭМЖСЭН БАЙГУУЛЛАГУУД

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Мэдээлэл Холбооны Операторуудын Ассоциаци

+976 7000-0160

www.mediacouncil.mn

info@mediacouncil.mn

Хэвлэл мэдээллийн зөвлөл